# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 32 (365)

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *Монгол Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай*

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Улсын үзлэгийн мөрөөр авах зарим арга хэмжээний тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2004 он

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын

Улаанбаатар хот 2004 оны наймдугаар сарын 16 №32 (365)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

337. Монгол Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай Дугаар 01 677

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

338. БНСУ-ын зарим иргэнийг одон медалиар шагнах тухай Дугаар 128 679

### Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

339. Хэлэлцээр батлах тухай Дугаар 147 679

340. Улсын үзлэгийн мөрөөр авах зарим арга хэмжээний тухай Дугаар 150 679

341. Дүрэмд өөрчлөлт оруулах тухай Дугаар 151 680

342. Засгийн газрын хүндэт өргөмжлөлөөр шагнах тухай Дугаар 154 680

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2004 оны 7 дугаар сарын 26–ны өдөр** **Дугаар 01** **Улаанбаатар хот**

**Монгол Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай**

2004 оны 6 дугаар сарын 27-ны өдөр явуулсан Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн дүн, Монгол Улсын Үндсэн хуулийн хорин гуравдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон дор дурдсан нэр бүхий гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсүгэй:

1/ 1 дүгээр тойрог
- Раднаасүмбэрэлийн Гончигдорж

2/ 2 дугаар тойрог
- Нямжавын Батбаяр

3/ 3 дугаар тойрог
- Самбуугийн Ламбаа

4/ 4 дүгээр тойрог
- Аукетайн Мурат

5/ 5 дугаар тойрог
- Агыпарын Бакей

6/ 6 дугаар тойрог
- Кадырын Сайраан

7/ 7 дугаар тойрог
- Гомбожавын Занданшатар

8/ 8 дугаар тойрог
- Цэрэнгийн Жаргал

9/ 9 дүгээр тойрог
- Халтмаагийн Баттулга

10/ 10 дугаар тойрог
- Чойжамцын Раднаа

11/ 11 дүгээр тойрог
- Цэгмидийн Цэнгэл

12/ 12 дугаар тойрог
- Түвдэнгийн Очирхүү

13/ 13 дугаар тойрог
- Аюурзаны Цанжид

14/ 14 дүгээр тойрог
- Лувсангийн Одончимэд

15/ 15 дугаар тойрог
- Цэрэнхүүгийн Шаравдорж

17/ 17 дугаар тойрог
- Мөнхчулууны Зоригт
18/ 18 дугаар тойрог
- Жамъяндоржийн Батхуяг
19/ 19 дүгээр тойрог
- Раднаабазарын Раш
20/ 20 дугаар тойрог
- Жанлавын Наранцацралт
21/ 21 дүгээр тойрог
- Чойнзонгийн Содномцэрэн
22/ 22 дугаар тойрог
- Дапзандаржаагийн Туяа
23/ 23 дугаар тойрог
- Ядамсүрэнгийн Санжмятав
24/ 25 дугаар тойрог
- Гаваагийн Батхүү
25/ 26 дугаар тойрог
- Данзангийн Лүндээжанцан
26/ 27 дугаар тойрог
- Рагчаагийн Бадамдамдин
27/ 28 дугаар тойрог
- Дашдэмбэрэлийн Бат-Эрдэнэ
28/ 29 дүгээр тойрог
- Цэвэлмаагийн Баярсайхан
29/ 30 дугаар тойрог
- Чүлтэмийн Улаан
30/ 31 дүгээр тойрог
- Рэнцэнгийн Буд
31/ 32 дугаар тойрог
- Сангажавын Баярцогт
32/ 33 дугаар тойрог
- Рэгжийбуугийн Нямсүрэн
33/ 34 дүгээр тойрог
- Эрдэнийн Бат-Үүл
34/ 35 дугаар тойрог
-Долгонгийн Дондог
35/ 36 дугаар тойрог
- Сундуйн Батболд
36/ 37 дугаар тойрог
- Цэндийн Сүхбаатар
37/ 38 дугаар тойрог
- Нямаагийн Энхболд
38/ 39 дүгээр тойрог
- Цэндийн Нямдорж
39/ 40 дүгээр тойрог
- Баатарын Эрдэнэсүрэн
40/ 41 дүгээр тойрог
- Чилхаажавын Авдай
41/ 42 дугаар тойрог
- Цэрэндашийн Дамиран
42/ 43 дугаар тойрог
- Лханаасүрэнгийн Пүрэвдорж
43/ 44 дүгээр тойрог
- Дамдины Дэмбэрэл
44/ 45 дугаар тойрог
- Ламжавын Гүндалай
45/ 46 дугаар тойрог
- Ономоогийн Энхсайхан
46/ 47 дугаар тойрог
- Мэндсайханы Энхсайхан
47/ 48 дугаар тойрог
- Бадарчийн Эрдэнэбат
48/ 49 дүгээр тойрог
- Дашжамцын Арвин
49/ 50 дугаар тойрог
- Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ
50/ 51 дүгээр тойрог
- Ухнаагийн Хүрэлсүх
51/ 52 дугаар тойрог
- Лүймэдийн Гансүх
52/ 53 дугаар тойрог
- Мишигийн Сономпил
53/ 54 дүгээр тойрог
- Батаагийн Цэрэнбалжир
54/ 55 дугаар тойрог
- Дүрзээгийн Одхүү
55/ 56 дугаар тойрог
- Горчинсүрэнгийн Адъяа
56/ 57 дугаар тойрог
- Төгсжаргалын Ганди
57/ 58 дугаар тойрог
- Даваажавын Ганхуяг
58/ 60 дугаар тойрог
- Сайнбуянгийн Отгонбаяр
59/ 61 дүгээр тойрог
- Надмидын Баяртсайхан
60/ 62 дугаар тойрог
- Долоонжингийн Идэвхтэн
61/ 63 дугаар тойрог
- Бүдээгийн Мөнхтуяа
62/ 64 дүгээр тойрог
- Ринчиннямын Амаржаргал
63/ 65 дугаар тойрог
- Намбарын Энхбаяр
64/ 66 дугаар тойрог
- Батын Батбаатар
65/ 67 дугаар тойрог
- Түнжингийн Бадамжунай
66/ 68 дугаар тойрог
- Дэндэвийн Тэрбишдагва
67/ 69 дүгээр тойрог
- Санжаасүрэнгийн Оюун
68/ 70 дугаар тойрог
- Базарсадын Жаргалсайхан
69/ 71 дүгээр тойрог
- Батжаргалын Батбаяр
70/ 72 дугаар тойрог
- Равжихын Эрдэнэбүрэн
71/ 73 дугаар тойрог
- Цогтын Батаа
72/ 74 дүгээр тойрог
- Цэндийн Мөнх-Оргил
73/ 75 дугаар тойрог
- Сүхбаатарын Батболд
74/ 76 дугаар тойрог
- Лувсаннямын Гантөмөр

**ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ Д.ДЭМБЭРЭЛ**

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ 2004 он №32 (365)

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2004 оны 7 дугаар сарын 28 -ны өдөр** **Дугаар 128** **Улаанбаатар хот**

**БНСУ-ын зарим иргэнийг одон, медалиар шагнах тухай**

Монгол, Солонгосын эрүүл мэнд, боловсролын салбарын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оруулж буй хувь нэмрийг нь үнэлж БНСУ- Монголын хамтын ажиллагааны нийгэмлэгийн дэд дарга, "Сөн Ай" эмнэлгийн эзэн Ким Юн Гван-ыг "Алтан гадас" одонгоор, тус нийгэмлэгийн дарга Жү Ян Жа-г "Найрамдал" медалиар тус тус шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2004 оны 7 дугаар сарын 7 –ны өдөр** **Дугаар 147** **Улаанбаатар хот**

**Хэлэлцээр батлах тухай**

Олон улсын гэрээний тухай хуулийн 14.3-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

2004 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр Каир хотноо гарын үсэг зурсан «Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Арабын Бүгд Найрамдах Египет Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр»-ийг батлсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР**

**ДЭД БҮТЦИЙН САЙД Б.ЖИГЖИД**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2004 оны 7 дугаар сарын 7 –ны өдөр** **Дугаар 150** **Улаанбаатар хот**

**Улсын үзлэгийн мөрөөр авах зарим арга хэмжээний тухай**

Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагуудын ажлын зохион байгуулалтын улсын үзлэг явагдсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улсын үзлэгийн явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах талаар зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ авч архив, албан хэрэг хөтлөлттэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтэд анхаарч ажиллахыг яам, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагийн удирдлага, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2. Байгууллагын албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагааг мэдээллийн технологийн үндсэн дээр шинэчлэн сайжруулах, архивын сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалтын зохистой нөхцөлийг бүрдүүлэх, архив, бичиг хэргийн ажилтнуудыг мэргэшүүлэх, давтан сургахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүр төсөвтөө тусган хэрэгжүүлж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт үүрэг болгосугай.

3. Төрийн болон нутгийн захиргааны байгууллагад ажиллаж байгаа архив, бичиг хэргийн ажилтнуудыг сургаж бэлтгэх, мэргэшлийг нь дээшлүүлэх талаар дор дурдсан арга хэмжээ авахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаяр, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид нарт тус тус даалгасугай:

а)архив, бичиг хэргийн ажилтныг сургаж бэлтгэх нэгдсэн тогтолцоо бий болгох асуудлыг судалж шийдвэрлэх;

б)байгууллагын архив, бичиг хэргийн ажилтнуудад мэргэшлийн зэрэг олгох журам тогтоож мөрдүүлэх.

4. Төрийн байгууллагын албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагаанд мэдээллийн технологийн ололтыг нэвтрүүлэх талаар нэгдсэн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хамт 2005 оны эхний хагас жилд багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид даалгасугай.

5. Архивын тухай хуулийн 14.1, Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 5 дахь заалтын дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт хийгдсэн газрын тосныхоос бусад геологийн хайгуулын бүх төрлийн ажлын тайлан, холбогдох материалыг төвлөрсөн журмаар хадгалах, ашиглах, мэдээллийн нэгдсэн сан байгуулах зорилгоор нэг хувийг нь Ашигт малтмалын хэрэг эрхлэх газрын Геологийн мэдээллийн төвд шилжүүлж байхыг холбогдох байгууллагуудын удирдлагад үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР**

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД Ц.НЯМДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**004 оны 7 дугаар арын 7 –ны өдөр** **Дугаар 151** **Улаанбаатар хот**

### Дүрэмд өөрчлөлт оруулах тухай

Үндэсний их баяр наадмын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2003 оны 164 дүгээр огтоолоор батлагдсан "Үндэсний их баяр наадмын үндэсний бөхийн барилдааны дүрэм"-ийн 3.6-г дор дурдсанаар өөрчилсүгэй:

"3.6.Үндэсний их баяр наадамд барилдах бөхчүүдийг цол, амжилтаар нь дараахь байдлаар эрэмбэлэн жагсаалтад оруулна:"

2. Мөн дүрмийн 3.1-ийн "...2 хоногийн өмнөх өдрийн 10.00 цагаас эхлэн бүртгэж, баяр наадмын өмнөх өдрийн 18.00 цагт дуусгана" гэснийг "...долоо хоногийн өмнө бүртгэж дуусгана" гэж өөрчлөн найруулсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД** **Н.ЭНХБАЯР**

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД** **П.НЯМДАВАА**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2004 оны 7 дугаар сарын 7 –ны өдөр** **Дугаар 154** **Улаанбаатар хот**

### Засгийн газрын Хүндэт өргөмжлөлөөр шагнах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Ардын хувьсгалын 83 жилийн ойг тохиолдуулан дор дурдсан хүмүүсийг Монгол Улсын Засгийн газрын Хүндэт өргөмжлөлөөр шагнасугай:

1.Жамбалдоржийн Бадраа
Төр, засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын дарга

2.Бямбаагийн Дашдорж
Үйлдвэр, худалдааны яамны Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын орлогч дарга

3.Дагдангийн Жанцан
Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Хөдөлмөр эрхлэлтийн газрын дарга

4.Бат-Өлзийн Жаргалсайхан
Багануур ХХК-ийн бульдозерчин

5.Очирын Лхагварэнцэн
Цагаатгах ажлыг зохион байгуулах улсын комиссын ахлах зохион байгуулагч

6.Өлзийбаярын Отгонбаатар
Монголын үндэсний телевизийн «ММ» агентлагийн сурвалжлагч

7.Жаргалсайханы Өсөхбаяр
Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн захирагч, ахмад

8.Юмчмаагийн Пүрэвсүрэн
Улсын клиникийн 2 дугаар нэгдсэн эмнэлгийн их эмч

9.Данзангийн Раднаарагчаа
Хүнс, хөдөө аж ахуйн яамны Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төвийн захирал

10.Бадарчийн Сувд
Гадаад хэргийн яамны Бодлого төлөвлөлт, мэдээлэл, үнэлгээний газрын захирал

11.Ёндонгийн Төрмандах
Хөвсгөл аймаг дахь 0257 дугаар ангийн 8 дугаар заставын дарга, ахлах ахлагч

12.Дуламжавын Түмэнхүү
Хан Хэнтийн тусгай хамгаалалттай газар, нутгийн хамгаалалтын захиргааны дарга

13.Даваагийн Энхцэцэг
Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Гуулин тосгоны 8 жилийн дунд сургуулийн багш

14.Түвшинтөрийн Энхцэцэг
Улсын гаалийн ерөнхий газрын харьяа Замын-Үүд дэх гаалийн газрын улсын ахлах байцаагч.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД** **Н.ЭНХБАЯР**

**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА** **Ө.ЭНХТҮВШИН**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
**"Төрийн Мэдээлэл"** эмхтгэлийн зөвлөл
Улаанбаатар- 12,
Төрийн ордон
☎ 329612 Индекс 14003

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.
☎ 329487
Хэвлэлийн хуудас 0.5